

## ЦАГДАА, ДОТООДЫН ЦЭРГИЙН БАЙГУУЛЛАГЫН 2022 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас Монгол Улсын Үндсэн хууль, Цагдаагийн албаны тухай, Дотоодын цэргийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиглэлээр гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, улсын онц чухал объектыг хамгаалах үндсэн чиг үүргийн хүрээнд 2022 онд дэвшүүлсэн зорилт, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллалаа.

### **Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар**

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 189 дүгээр тушаалаар баталсан “Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал”-аар 2021 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн, Монгол Улсын 2022 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан, цагдаагийн байгууллага хариуцан хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний биелэлт, “Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө”-нд цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас тусгуулах саналыг тус тус Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж тайлагнасан.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2022 онд хяналтад авч, хэрэгжилтийг зохион байгуулах, мэдээлэх, хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх баримт бичгийн жагсаалтыг энэ оны А/38 дугаар тушаалаар баталж, цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагад хүргүүлэн, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2022 онд “Хүний эрхийг дээдлэн үйл ажиллагаандаа иргэдийн оролцоо, дэвшилтэт технологийн ашиглалтыг нэмэгдүүлнэ”, “Алба хаагчдын эрүүл мэнд, хууль ёсны эрх ашгийг хамгаалж, хүний нөөцийн тогтвортой байдлыг бүрдүүлнэ” гэсэн зорилтыг дэвшүүлэн Цагдаа, дотоодын цэргийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн энэ оны А/01 дүгээр тушаалаар батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Цагдаагийн ерөнхий газрын даргын зөвлөлийн 2022 оны хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг баталж, энэ оны эхний хагас жилийн байдлаар 6 удаа хуралдан, хуралдаанаас гарсан шийдвэр, мэдээлэл, үүрэг, ажлын чиглэлийг холбогдох анги, байгууллагад тухай бүр хүргүүлж, үр дүнг тооцон ажилласан.

Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчаас болон Тэргүүн дэд, Дэд, Захиргааны удирдлагын газрын дарга нараас цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан байгууллагын үндсэн үйл ажиллагаанд чиглэсэн 216 тушаал, 38 удаагийн үүрэг, ажлын чиглэл, зөвлөмж өгснийг анги, байгууллагад хүргүүлэн, хэрэгжилтийг тооцсон.

**1.1.Соён гэгээрүүлэх, албаны сургалтын чиглэлээр:** “Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын 2022 оны албаны сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө”-ний дагуу албаны /ажлын байрны/ 2929 удаагийн сургалтад давхардсан тоогоор 425.424, “Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх давтан, мэргэшүүлэх 2022 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөө”-ний дагуу 69 удаагийн танхимын болон цахим сургалтад 8527 алба хаагчийг хамруулан үр дүнг тооцож, “Соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөө”-ний дагуу 1984 удаа соёл,

хүмүүжлийн мэдээлэл, сурталчилгааг давхардсан тоогоор 215.154 алба хаагчид хүргэж ажилласан.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөх холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмуудыг алба хаагчдад судлуулах, зорилгоор гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр 67 удаагийн сургалтад 5305, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр 15 удаагийн сургалтад 6076, Тээврийн цагдаагийн албаны чиглэлээр 42 удаагийн сургалтад 13864, Дотоодын цэргийн үйл ажиллагаа, улсын онц чухал объектын аюулгүй байдлыг хангах чиглэлээр 20 удаагийн сургалтад 23604, Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын чиглэлээр 22 удаагийн сургалтад 4317 алба хаагчид тус тус хамрагдаж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр нутаг дэвсгэрийн төр, захиргаа, хууль хяналтын байгууллагатай хамтран 1420 удаагийн сургалт, зөвлөгөөнийг зохион байгуулж, 18923 алба хаагчийг хамруулсан.

Алба хаагчдын үйл ажиллагааг мэргэшүүлэх, сурган зааварчлах зорилгоор Багшийн мэргэжил дээшлүүлэх институттэй хамтран алба хаагчдыг сурган зааварчлах сургагч багш бэлтгэх сургалтаар 61, мансууруулах эм, сэтгэгцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, өсвөр насны хүүхэд залуучуудыг хорт зуршлаас ангид байлгах, хараа хяналтыг сайжруулах чиглэлээр тэдний эцэг эх багш нийгмийн ажилтнуудад чиглэсэн сургалт, мэдээллийн ажлыг зохион байгуулах сургагч багш бэлтгэх сургалтаар 32, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллах мөрдөгч, хүүхдийн асуудал хариуцсан алба хаагч сургагч багшаар бэлтгэх сургалтаар 60, цагдаа, иргэний харилцааны менежментийг сайжруулах сургагч багш бэлтгэх сургалтаар 19, авлигын эсрэг сургалт явуулах сургагч багшаар 52, нийт 5 удаагийн сургалт зохион байгуулж, 224 алба хаагчийг сургаж бэлтгэсэн.

Алба хаагчдын мэдлэг, ур чадвар, боловсролын түвшинг дээшлүүлэх зорилгоор дотоод, гадаадын их дээд сургуулиудтай хамтран ажиллаж, цагдаагийн байгууллагын захиалгаар Дотоод хэргийн их сургуулийн бакалаврын боловсролын эчнээ хөтөлбөрийн сургалтад 145, магистрын хөтөлбөрийн сургалтад 45, докторын хөтөлбөрийн сургалтад 8, Удирдлагын сургуульд 13, АНУ, ОХУ, БНХАУ, БНТУ, БНСУ, БНУУ зэрэг 6 улсын цагдаагийн байгууллага, академи, их, дээд сургуульд боловсролын адъюнктур, доктор, магистрантур, бакалаврын сургалтад 89, нийт 300 алба хаагчийг суралцуулж байна.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2022 онд дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын удирдах ажилтны 2022 оны сургалт, зөвлөгөөн”-ийг зохион байгуулж нийт **208** удирдах ажилтныг хамруулсан.

Сургалт, зөвлөгөөнийг удирдах ажилтны манлайлал, арга барилыг дээшлүүлэх, хөгжүүлэхэд чиглүүлж, хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргийн хүрээнд алба, нэгж болон хамтын ажиллагааны талаар Хууль зүй, дотоод хэргийн яам, Төрийн албаны зөвлөл, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын алба, Хүний эрхийн үндэсний комисс, Улсын ерөнхий прокурорын газар, Тагнуулын ерөнхий газар, Авлигатай тэмцэх газар, Дотоод хэргийн их сургууль зэрэг 8 байгууллагаас мэдээ, мэдээлэл хийж, харилцан санал солилцсон.

Цагдаагийн төв байгууллагаас алба хаагчдын мэргэжлийн мэдлэг, ур чадвар, гадаад хэлний боловсролыг дээшлүүлэх, гадаад, дотоодын төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр мэргэшүүлэх, боловсролын түвшинг ахиулах зорилгоор “Хуурамч бичиг баримтыг таних, бусдын баримт бичгийг ашиглагч, залилагч этгээдийг таних нь”, “Дижитал буюу цахим

нотлох баримт цуглуулах”, “Криптовалют”, Санхүүгийн мөрдлөг”, “Кибер гэмт хэргийг мөрдөн шалгах арга зүй”, “Аюултай химийн бодис, хог хаягдлын хууль бус эргэлттэй тэмцэх” зэрэг 9 удаагийн сургалтад 215 алба хаагчийг хамруулсан.

Мөн алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалтын нэгдсэн хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу төв, орон нутгийн алба хаагчдыг мэргэшүүлэх сургалтад хамруулах зорилгоор “Хүний эрх ба алба хаагчийн эрх, үүрэг”, “Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга зүй”, “Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга зүй” сэдэвт 4 удаагийн бүсчилсэн сургалтыг зохион байгуулж, 9875 алба хаагчийг хамруулсан.

Алба хаагчдын сургалтад зориулж 251 хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан, 195 аудио, видео бичлэг, богино хэмжээний кино бүтээж, 991 ширхэг гарын авлага, тараах материал, бодлого, аргачлал хэвлүүлэн тарааж, сургалтад нийт 19.6 сая төгрөг зарцуулсан.

**1.2.Гадаад харилцаа, энхийг сахиулах ажиллагааны ажиллагааны чиглэлээр:** Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс ирүүлсэн зөвлөмжийн дагуу энхийг сахиулах ажиллагаа хариуцсан чиг үүрэг бүхий 3 алба хаагчийн орон тоог нэмэгдүүлж, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Энхийг сахиулах ажиллагааны Энхийг сахиулах төв, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Засгийн газартай хамтран НҮБ-ын Мөрдөн байцаагчийн үндэсний сургагч багшийн сургалт (UN National Investigation Officer Training of Trainers UNNIO TOT)-д 2, НҮБ-ын ЭСА-ны “Сургагч багшийн дамжаа”-нд 8, АНУ-ын Сангийн яамны Татварын хяналтын албаны Эрүүгийн мөрдөн шалгах хэлтсээс зохион байгуулсан “Худалдаанд суурилсан мөнгө угаалт ба НӨАТ-ын залилан” сэдэвт цахим сургалтад 20, Оросын Холбооны Улсын Дотоод хэргийн яамны харьяа Воронеж хотын Дотоод хэргийн дээд сургуультай хамтран Эрүүгийн цагдаагийн албаны чиглэлээр явуулсан цахим сургалтад 10 алба хаагчийг тус тус хамруулсан.

Бүгд Найрамдах Солонгос Улсын Үндэсний цагдаагийн газар /ҮЦГ/-ын алба хаагчдын “Монгол Улсын Цагдаагийн байгууллагын хар тамхи, мансууруулах бодистой тэмцэх чадавх бэхжүүлэх” төсөл, Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яам, Бүгд Найрамдах Киргиз Улсын Дотоод хэргийн яам хоорондын хамтын ажиллагааны тухай гэрээний төслийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Бүгд Найрамдах Энэтхэг Улс дахь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Энхийг дэмжих ажиллагааны төвд зохион байгуулагдсан “НҮБ-ын Үндэсний мөрдөгчийн сургагч багш бэлтгэх” сургалтад 2 алба хаагчийг бэлтгэсэн.

АНУ-аас Монгол Улсад суугаа элчин сайдын яам, АНУ-ын Төрийн департаментийн санхүүжилтээр Монгол Улсын цагдаагийн байгууллагын теле хяналтын камерын нөхцөл байдлыг сайжруулах төсөл хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлагын талаарх танилцуулга болон төслийн техник, эдийн засгийн үзүүлэлтийн тооцоог гаргаж, тус элчин сайдын яаманд хүргүүлсэн.

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагаас Нэгдсэн Үндэстний Байгууллагын мандаттай Олон Улсын Энхийг дэмжих ажиллагаанд Зэвсэгт хүчний цэргийн багийн бүрэлдэхүүнд 2006 оноос эхлэн Сьерра Леон Улсад явагдсан “UNMIL” ажиллагаанд 81, Чад Улсад 1, Иракийн “Эрх чөлөө” ажиллагаанд 5, Афганистан Улсад “Шийдвэртэй дэмжлэг” ажиллагаанд 9 алба хаагч, 2012 оноос эхлэн Бүгд Найрамдах Өмнөд Судан Улс дахь НҮБ-ын энхийг сахиулах “UNMISS” ажиллагаанд 10 удаагийн ээлжинд нийт 414 алба хаагч дэлхийн энх тайван,

аюулгүй байдлыг хангах үйл хэрэгт оролцож, одоогоор 31 алба хаагч үүрэг гүйцэтгэж байна.

**1.3.Үйл ажиллагаатай холбоотой хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр:** Цагдаагийн ерөнхий газарт холбогдох эрүү, иргэн, захиргааны 21 хэргийн шүүх хуралдаанд хариуцагч, нэхэмжлэгчийн төлөөлөгчөөр 34 удаа оролцсон.

“Цагдаа, дотоодын цэргийн алба хаагч, ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах орон тооны бус зөвлөл”-ийн гуравдугаар хуралдааныг цахимаар зохион байгуулж, “Цагдаа, дотоодын цэргийн алба хаагч, ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах хөтөлбөр, төлөвлөгөө”-ний 2021 оны биелэлтэд хийсэн хяналт, шинжилгээний тайланг хэлэлцэж холбогдох үүрэг, ажлын чиглэлийг хүргүүлж, алба хаагчид хууль зүйн зөвлөгөө, эрх зүйн туслалцаа үзүүлэх талаар 50 асуудлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд судлан удирдах албан тушаалтанд танилцуулж, шийдвэрлүүлсэн.

Алба хаагч, ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөж зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, алба хаагчдын эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, тэдэнтэй харилцан мэдээлэл солилцох, хууль зүйн туслалцаа үзүүлэх, ирүүлсэн санал, хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэх зорилгоор нээсэн 9418 дагагчтай “Алба хаагчдын чөлөөт индэр” фэйсбүүк хязгаарлалттай группээр дамжуулан “Хариуцсан чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлж буй ажил, арга хэмжээ, баримтлах бодлого, алба хаагч, ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр зохион байгуулж байгаа шинэлэг ажил, цаашид хэрэгжүүлэх ажил, арга хэмжээ” сэдвээр нийт 38 удаагийн шууд дамжуулалт /live/ хийж, давхардсан тоогоор 213.028 алба хаагч үзэж, 11181 алба хаагчид таалагдаж, алба хаагчдаас коммент хэсгээр ирүүлсэн 11050 сэтгэгдлээс 238, үүрэн холбооны утсаар ирүүлсэн 3 асуултад тус тус хариулт өгч, 12 удаагийн лайвын талаарх мэдээллийг цагдаагийн төв байгууллагын удирдлагад танилцуулж, өгсөн үүргийн хэрэгжилтийг хангуулахаар холбогдох анги, байгууллагад хүргүүлсэн.

Шүүхийн шинжилгээний тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж гарах Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай зэрэг 6 хууль, эрх зүйн 20 актын төслийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий Хууль зүйн байнгын хорооны Ажлын хэсгийн хуралдаанд оролцож, санал боловсруулан ажилласан.

Монгол Улсын хуулийн төсөлд санал өгөх, боловсруулах чиглэлээр НҮБ-ын конвенц болон түүний нэмэлт протоколуудын хэрэгжилтийн тайлан гаргах 2, холбогдох хууль тогтоомжийн 10 төсөлд санал өгөх, боловсруулах Ажлын хэсэгт цагдаагийн байгууллагыг төлөөлөн ажиллаж, эрх зүйн актын 34 төсөлд цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагаас санал авч, Хууль зүй, дотоод хэргийн яам болон холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлсэн.

Гадаад улстай байгуулах хэлэлцээрийн 1, хамтран ажиллах санамж бичгийн 1, төрийн болон бусад байгууллагатай хамтран ажиллах 8, ажил гүйцэтгэх 6, даатгалын 3, түрээсийн 2 гэрээний төслийг тус тус хянаж, холбогдох байгууллагад хүргүүлсэн.

Цагдаагийн ерөнхий газрын даргын батлан гаргасан 22 хэм хэмжээ тогтоосон эрх зүйн баримт бичгийн талаарх мэдээллийг цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын алба хаагчдад хүргүүлж, мэдээллээр хангасан.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагад хууль тогтоомжоор боловсруулсан гарын авлага, мэдээлэл 4, эрх зүйн акт /Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг 1, Засгийн газрын тогтоол 1, сайдын тушаал 5, Цагдаагийн ерөнхий газрын даргын 12 тушаалын талаарх мэдээллийг тухай бүр хүргүүлж, цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хамааралтай Засгийн газрын 40 тогтоол, Хууль зүй, дотоод хэргийн сайдын дангаар болон хамтран баталсан 70, Цагдаагийн ерөнхий газрын даргын дангаар болон хамтран баталсан 56, Улсын Ерөнхий прокурорын 19 тушаалд баяжилт хийж, тухай бүр цагдаагийн байгууллагын [www.police.gov.mn](http://www.police.gov.mn), [www.system.police.gov](http://www.system.police.gov) цахим хуудсанд байршуулсан.

**1.4. Хүний нөөцийн чиглэлээр:** Харьяа алба, нэгж, байгууллагаас ирүүлсэн хүний нөөцийн томилолттой холбоотой хүсэлтүүдийг хүлээн авч удирдлагад танилцуулан Цагдаагийн ерөнхий газрын даргын 871, Дотоодын цэргийн командлагчийн 47, Цагдаагийн ерөнхий газрын Дэд даргын 20, Захиргааны удирдлагын газрын даргын 37, нийт 975 тушаалаар 5196 алба хаагчийн хүний нөөцийн асуудлыг шийдвэрлэсэн.

Албан тушаал дэвших, шилжих болон шинээр томилогдох 775 алба хаагчийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийн эрх нээж, цахим санд бүртгэн, бөглүүлж, 98 албан бичгээр Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн. Үүнээс 767 алба хаагчийн хариу ирсэн, 8 алба хаагчийн мэдүүлэг хянагдаж байна.

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагаас 2022 онд албан тушаал дэвшүүлэх нөөцөд бүртгүүлэх санал ирүүлсэн 1258 алба хаагчийн материалыг нэгтгэж, шалгуур, шаардлага хангасан эсэхэд тулгалт хийн, Төрийн албаны зөвлөлийн Цагдаагийн ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлийн 2022.02.15-ны өдрийн б/02 дугаар тогтоолоор ахлагчаас офицер албан тушаалд 332, ахлах албан тушаалд 481, чиглэлийн ахлах, тасаг, хэсгийн даргын албан тушаалд 226, алба, газар, хэлтсийн даргын албан тушаалд 99, нийт 1138 алба хаагчийг албан тушаал шатлан дэвшүүлэх сургалтад хамруулахаар нөөцийн жагсаалтад бүртгэсэн.

Цагдаагийн ерөнхий газрын даргын зөвлөлийн хуралдааны шийдвэрээр бүтцийн өөрчлөлтөөр 369, шилжүүлэн буюу зохицуулан томилсон 201, цагдаагаас офицерын бүрэлдэхүүнд 69, хүүхэд асрах чөлөө цуцалсан 10, албан тушаалд дэвшүүлэн томилсон 123, бусад байгууллагаас шилжүүлэн томилсон 8, нөөцөөс томилсон 12, төрийн өөр байгууллагаас шилжүүлэн буюу сэлгэн томилсон 8, шүүхийн шийдвэрээр 2, албан тушаал буурсан 14, цагдаагаар 21 алба хаагчийг тус тус томилсон.

Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1, 44.2 дахь заалтаар 4, эрүүл мэндээр 1, өөрийн хүсэлтээр 37, тэтгэвэрт 19, хүүхэд асрах чөлөө олгосон 13, цагдаагийн байгууллагын ёс зүйг ноцтой зөрчиж халагдсан 4, сахилгын шийтгэлээр 1 жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр 13 алба хаагчийг тус тус албанаас чөлөөлж, 1 алба хаагчаар албан үүргийг түр орлон гүйцэтгүүлж, 2 алба хаагчийг үүрэг гүйцэтгэгчээр томилсон.

Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагад нэмэгдүүлсэн 568 орон тооны хуваарилалтын талаар харьяа албад, газар, хэлтэс, төвөөс санал авч, танилцуулга бэлтгэн, удирдлагад танилцуулж, Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар мэдээлэл, технологийн чиглэлээр 9, түүх, соёлын дурсгалт зүйлийн хууль бус эргэлттэй тэмцэх чиглэлээр 5, мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр 2, гадаад харилцаа, энхийг сахиулах ажиллагааны чиглэлээр 3, шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр 10, Автобаазад цагдаа жолооч 10, дүүрэг дэх Замын цагдаагийн хэлтсүүдэд Нийслэлийн гудамж, замд шөнийн цагт хяналт тавьж ажиллах чиг үүрэг бүхий 72, зарим аймаг дахь цагдаагийн газарт 13, орон нутаг дахь баривчлах

шийтгэл оногдуулсан шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэх чиг үүргийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад шилжүүлэхтэй холбоотой 15, Зөрчлийн хэрэг бүртгэх газар шинээр байгуулагдсантай холбогдуулан 15, Дотоодын цэргийн анги, байгууллагуудад 194, нийт 354 орон тоог хуваарилан, алба хаагчдын томилолтын асуудлыг шийдвэрлэснээр нэг алба хаагчид оногдох ажлын ачаалал буурахад эерэг нөлөө үзүүлэх боломжийг бүрдүүлсэн.

Мөн харьяа албад, газар, хэлтэс, төвөөс ирүүлсэн саналын дагуу Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах алба, Экологийн цагдаагийн алба, Тээврийн цагдаагийн алба, Дотоод хяналт-аюулгүй байдлын газар, Дотоодын цэргийн штаб, Бүртгэл хяналтын төв, Төв архив, Баянхонгор, Хэнтий, Төв, Сүхбаатар, Өмнөговь, Ховд, Говьсүмбэр аймаг дахь цагдаагийн газар, хэлтсийн зарим албан тушаал, орон тоо, цол, цалингийн зэрэглэлд өөрчлөлт оруулах асуудлыг шийдвэрлэсэн.

Цагдаагийн байгууллага үүсэн байгуулагдсаны 101, Дотоодын цэргийн түүхт 100 жилийн ойг тохиолдуулан Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас Төрийн одон, медалиар шагнуулахаар нэр дэвшсэн 210, Хууль зүй, дотоод хэргийн яамны шагналаар шагнуулахаар нэр дэвшсэн 194, нийт 404 алба хаагчийн материалыг хүлээн авч, судлан 187 алба хаагч, ажилтныг төрийн одон медаль, 190 алба хаагч, ахмад ажилтныг Хууль зүй, дотоод хэргийн яамны шагналаар шагнуулах саналтай материалыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажилд идэвх зүтгэл, үр бүтээл гарган ажилласан алба хаагч, ахмад ажилтнуудын материалыг хүлээн авч судлан удирдлагад танилцуулж, Цагдаагийн ерөнхий газрын “Цагдаагийн гавьяа” тэмдгээр 25, “Дотоодын цэргийн алдар” тэмдгээр 11, “Цагдаагийн төлөө” тэмдгээр 1, “Монгол цагдаа” тэмдгээр 48, “Хүндэт жуух”-аар 51, эрүүгийн цагдаагийн хүндэт тэмдгээр 2, Спортын алдар тэмдгээр 1, цалингийн тодорхой хувиар 1, нийт 140 алба хаагч, ахмад ажилтнуудыг шагнаж урамшуулсан.

**1.5. Улсын онц чухал объектын харуул, хамгаалалтын чиглэлээр:** Улсын онц чухал объектын хамгаалалтыг зохион байгуулж, объектуудад давхардсан тоогоор 932019 ажилчин, 363264 иргэн, 1512 гадаадын иргэн, 284047 тээврийн хэрэгслийг тус тус шалган нэвтрүүлж, 405.693 хөдөлгөөнийг бүртгэн хяналт тавьж, 6652 тонн 91311 кг тэсэрч дэлбэрэх бодис, 1409773 метр, 1927235 ширхэг тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлтийн аюулгүй байдлыг ханган ажилласан.

Дулааны хоёрдугаар цахилгаан станц, Үндэсний дата төвийн нөөц төв, Дархан-Уул аймаг дахь ус хангамжийн эх үүсвэрийг хамгаалалтад хүлээн авсан.

Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн тушаалаар Дотоодын цэргийн 05, 805 дугаар ангиас нийт 190, Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны Эргүүл хамгаалалтын газраас 30, нийт 220 алба хаагчийг томилж, энэ оны 04 дүгээр сарын 13-ны өдрөөс Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дэвсгэр Цагаан хадны суурьшлын бүсэд коронавируст халдварын тархалтыг хумих, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчлийг таслан зогсоох зорилгоор түр хамгаалалтад аван ажиллаж байна.

Тайлант хугацаанд 7305 аж ахуйн нэгж, байгууллага, 44195 тээврийн хэрэгсэл, 50657 иргэнийг шалгаж, 2758 иргэнд зөвлөмж, зөвлөгөө өгч, 3939 хөдөлгөөнийг бүртгэн хяналт тавьж, суурьшлын бүс рүү 934 тээврийн хэрэгслийг буцааж, 57 тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлж, зориулалтын бус газраар

нэвтрэхийг оролдсон 10 иргэн, 662 тээврийн хэрэгслийг саатуулж, бүрэн бус тээврийн хэрэгсэлтэй замын хөдөлгөөнд оролцсон 58, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 64, тогтоосон дэглэм журам зөрчсөн 457, жолоодох эрхийн үнэмлэхийн хугацаа дууссан 23, Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн 40, нийт 642 зөрчлийг илрүүлж, эрэн сурвалжлагдаж байсан 4 иргэнийг саатуулан тус тус шалгуулахаар нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад шилжүүлсэн.

**1.6. Авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр:** Авлигын нийгмийн хор аюулыг олон нийтэд таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэхэд чиглэсэн соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах, төрийн алба хаагчдын шударга байдлыг нэмэгдүүлэх, ёс зүйг дээшлүүлэх, байгууллагын соёлыг тогтоох зорилгоор хэрэгжүүлж байгаа арга хэмжээнд Цагдаагийн байгууллагыг манлайлан оролцож, хамтран ажиллах хүсэлтийг Авлигатай тэмцэх газраас ирүүлсний дагуу Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын дарга, захирагч нарт “Зөв зөвд, шударга зөв” аяныг байгууллагын алба хаагчдад сурталчилж, “Авлигатай тэмцэх газар”, “АТГ-Олон нийтийн төв” пейж фэйсбүүк хуудаст QR кодыг уншуулан нэгдэх ажлыг зохион байгуулсан.

Худалдан авах ажиллагааны тендерийн үнэлгээний хорооны гишүүд болон хяналт шалгалт хариуцсан /давхардсан тоогоор/ 62 алба хаагчаас “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай” мэдэгдлийг гаргуулж, Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, цахим системийн Мэдэгдэл, тайлбарыг бүртгэх цэсэнд бүртгэж, Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хугацаа хожимдуулсан, томилогдсон буюу их хэмжээний өөрчлөлт орсон өдрөөс хойш 30 хоногийн дотор мэдүүлээгүй зөрчил гаргасан тохиолдолд Авлигын эсрэг хуульд заасан хариуцлага хүлээлгэх талаар анги, байгууллагад зөвлөмж хүргүүлсэн.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4-т заасны дагуу [shilendans.gov.mn](http://shilendans.gov.mn) сайт болон байгууллагын цахим хуудсанд, “Худалдан авах ажиллагааны 2022 оны төлөвлөгөөний хүрээнд хэрэгжүүлэх /давхардсан тоогоор/ нийт 42 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн урилга, үр дүнг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn), [www.police.gov.mn](http://www.police.gov.mn), [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn)-нд болон өдөр тутмын хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд холбогдох хууль, журмын дагуу тус тус байршуулж, олон нийтэд ил тод мэдээлсэн.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 4.1.1.10.3-т заасан “Авлигын эсрэг сургалт, давтан сургалтыг зохион байгуулах” зорилтын хүрээнд цагдаа, дотоодын цэргийн байгууллагын алба хаагчдад “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг мэдүүлэхэд анхаарах асуудал” сэдвээр “Алба хаагчдын чөлөөт индэр”-т 45 минутын шууд дамжуулалт /лайв/ мэдээлэл хүргүүлж, төрийн байгууллагуудын албан хаагчдыг авлигын эсрэг хууль тогтоомж, ашиг сонирхлын зөрчил, авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаарх мэдлэгийг нэмэгдүүлэхээр “Авлига, түүний шалтгаан, нөхцөл, үр дагавар, авлигаас урьдчилан сэргийлэх арга зам, Мэдэгдэл ба тайлбар гаргах нь” сэдэвт Авлигатай тэмцэх газрын цахим сургалтад 275 алба хаагчийг хамруулсан.

Монгол Улсын Засгийн газрын “Авлигын төсөөллийн шалгуур үзүүлэлт /индекс/-ийг бууруулах, хангах, эрчимжүүлсэн арга хэмжээний төлөвлөгөө”-ний цагдаагийн байгууллагад хамааралтай заалтын хэрэгжилтийг хангах, зохион байгуулах, үр дүнг тооцон үнэлэх үүрэг бүхий ажлын хэсгээс төлөвлөгөөний хэрэгжилтийг нэгтгэж, алба хаагчдыг авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын

индексийн түвшинг бууруулах чиглэлээр хэрэгжүүлж байгаа ажил, арга хэмжээ, түүний хэрэгжилт, тушаал шийдвэрийн биелэлтэд зааварчилга өгсөн.

Мөн ажлын хэсгийн шийдвэрийн дагуу алба хаагчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалах, авлига, ашиг сонирхлын зөрчилгүй байх мэдлэгийн түвшинг тогтоох зорилгоор нийт алба хаагчдаас цахим шалгалтыг 2 удаа зохион байгуулсан ба 6758 алба хаагч хамрагдсан.

“Авлигын эсрэг сургалт явуулах сургагч багш”-ийг чадавхжуулах, давтан сургалтад хамрагдсан алба хаагчдыг Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын алба хаагчид болон иргэдэд авлигын эсрэг хууль тогтоомж, сургалт, сурталчилгаа явуулах сургагч багшаар анги, байгууллагын 52 алба хаагчийг бэлтгэсэн.

**1.7.Эрсдэлийн үнэлгээний чиглэлээр:** Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хэмжээнд эрсдэлээ үнэлсэн байгууллагуудын эрсдэлийн үнэлгээний дүнг үндэслэн цагдаагийн байгууллагын 2021 оны эрсдэлийн үнэлгээг хийж, Цагдаагийн байгууллагын удирдлагад танилцуулах шаардлагатай “Ач холбогдлын зэрэг”-ээрээ “Их” эрсдэлтэй буюу 20-25 оноотой үнэлэгдсэн төсөв санхүүгийн 5, үйл ажиллагааны 36, нийцлийн 2, гадаад хүчин зүйлийн буюу давагдашгүй хүчин зүйлсийн 8, нийт 51 эрсдэлийг байгууллагад үзүүлэх нөлөөллийн түвшин, давтагдах магадлал, чанарын түвшнийг харгалзан нэгтгэсэн.

Эрсдэлийн үнэлгээ их түвшинд тодорхойлогдсон стратегийн, үйл ажиллагааны, нийцлийн, гадаад хүчин зүйлийн 29 эрсдэлийг бууруулах арга хэмжээний саналыг гаргаж, Хууль зүй, дотоод хэргийн сайдын дэргэдэх Дотоод аудитын хорооны хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэхээр хүргүүлж, Байгууллагын хэмжээнд дотооддоо зохион байгуулалтын арга хэмжээ авч, бууруулах боломжтой гэж үзэж байгаа стратегийн, үйл ажиллагааны, нийцлийн, гадаад хүчин зүйлийн 22 эрсдэлийг цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн болон эрсдэлийн менежментийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж байна.

Байгууллага алба хаагчийн аюулгүй байдалд учирч болох эрсдэлийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын Дотоод аюулгүй байдлыг хангах төлөвлөгөө, цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2022 оны эрсдэлийн менежментийн төлөвлөгөөг тус тус боловсруулж, учирч болох эрсдэлийг чанарын зэрэглэлээс нь хамааруулан удирдаж хянах, нэн шаардлагатай буюу өргөн хүрээнд удирдан зохион байгуулах шаардлагатай эрсдэлүүдийг шийдвэрлэн ажилласан.

**1.9.Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар:** Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын удирдах албан тушаалтанд 2022 оны эхний хагас жилд иргэд, байгууллагаас 12061 санал, өргөдөл, гомдол ирүүлснийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6667 нэгжээр буюу 123.6 хувиар өссөн бол нийт хүлээн авсан санал, өргөдөл, гомдлын 333 буюу 2.8 хувь нь санал, 11634 буюу 96.5 хувь нь өргөдөл, 94 буюу 0.8 хувь нь гомдол байна.

Нийт санал, өргөдөл, гомдлын 688 буюу 5.7 хувь нь ажилд орох, суралцахыг хүссэн, 181 буюу 1.5 хувь нь ажилд дахин орохыг хүссэн, 1770 буюу 14.7 хувь нь ажил өөрчлөх, шилжихийг хүссэн, 1783 буюу 14.8 хувь нь захиргааны чөлөө хүссэн, 287 буюу 2.4 хувь нь тэтгэвэр, тэтгэмж, орон сууц хүссэн, 7352 буюу 60.9 хувь нь бусад өргөдөл, гомдол байна. Нийт хүлээн авсан санал, өргөдөл, гомдлын 11943 буюу 99.0 хувийг шийдвэрлэж, 118 буюу 1.0 хувь нь хуулийн хугацаанд ажиллагаанд байна.



Энэ оны эхний хагас жилд иргэдээс Засгийн газрын “Иргэд, олон нийттэй харилцах төв”-д цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаатай холбоотой 136 санал хүсэлт, гомдол, шүүмжлэл, талархал, ирүүлсний 18 буюу 13.2 хувь нь санал хүсэлт, 88 буюу 64.7 хувь нь гомдол, 16 буюу 11.8 хувь нь хүсэлт, 14 буюу 10.3 хувь нь талархал байна.

Мөн иргэдээс ирүүлсэн санал хүсэлт, гомдол, шүүмжлэл, талархлын 117 буюу 86.0 хувийг шийдвэрлэж, 19 буюу 14.0 хувьд холбогдох алба, нэгж хуулийн хугацаанд шалгалтын ажиллагаа явуулж байна.

### **Хоёр. Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийн хэрэгжилтийн талаар**

**2.1.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр:** Хууль зүй, дотоод хэргийн яам, Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Нийслэлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Үндэсний дата төв, Харилцаа холбооны зохицуулах хороо, Нийслэлийн мэдээлэл технологийн газар, үүрэн телефоны Скайтел, Жи мобайл, Юнител оператор компанийн удирдах ажилтнуудыг оролцуулан “Халаасны хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулсан.

Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, архины зохисгүй хэрэглээг багасгах, тэднийг зөв үйлдэлд уриалах, согтуугаар үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор “Зөвийг зөвлөө”, хуурамч мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд оруулахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр “Хуурамч мөнгө”, “Тэнэмэл” арга хэмжээг зохион байгуулж, 112 иргэнийг эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулан, Нийслэлийн засаг даргын дэргэдэх Нийгмийн хамгааллын тусгай төв болон төрийн бус байгууллагуудад хүлээлгэн өгсөн.

Их, дээд болон ерөнхий боловсролын 1712 сургууль, зорилтод бүлгийн иргэд болон эрүүлжүүлэх саатуулах байранд хүргэгдсэн нийт 4331 иргэн, төрийн 596, төрийн бус 1223 байгууллагатай хамтран 543 удаагийн сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион явуулж, 9229 төрлийн зурагт хуудас, санамж, сэрэмжлүүлэг 44844 ширхгийг иргэд, олон нийтэд тарааж, төв, орон нутгийн 26 телевизийн зочны цагаар давхардсан тоогоор 105 удаа, 17 FM радио, 28 сонин, 36 цахим сайт /пейж/-д давхардсан тоогоор 1609 мэдээ, мэдээллийг байршуулан, хамтран ажилласан.

“Цагдаагийн ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх хэлтэс” пэйж хуудсаар “Цахим соёл”-ыг сурталчлах, хулгайлах, залилах, угаарын хий, зам тээврийн осол, хэрэг, гэр бүлийн хүчирхийлэл, согтуугаар үйлдэгдэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хүүхдийг гэнэтийн осол, аюулаас сэрэмжлүүлэх, ХАСХОМ мэдүүлэх заавар зэрэг нийт 4 лайв, 3 подкаст, 24 видео шторк, 65 постер, 54 мэдээлэл нийтэлж иргэдэд сэрэмжлүүлэг хүргэснийг 712.500 хүн үзэж, 22837 удаа бусадтай хуваалцсан байна.

Мөн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 8106 алба хаагч, 14585 иргэний цахим хуудсын ковер зургийг солиулж, давхардсан тоогоор 1277 видео шторк, 2748 постер, нийт 4025 контентийг бэлтгэн, Цагдаагийн ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх хэлтэс, алба, нэгж, дүүрэг, орон нутгийн цагдаагийн байгууллагын цахим хуудсанд байршуулсан нь 6,928,119 хүнд хүрч, 643.890 хүнд таалагдаж, 2.566.609 удаа бусадтай хуваалцсан байна.

Цагдаагийн байгууллагаас Олон Улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан энэ оны 06 дугаар сарын 01-ний өдөр цагдаа, дотоодын цэргийн байгууллагын үйл ажиллагааг иргэд, олон нийт, хүүхэд, багачуудад сурталчлах, үзэсгэлэн, урлаг, соёл, спортын уралдаан, тэмцээн, арга хэмжээнүүдийг багтаасан

“ХҮҮХЭД ТАНЫГ ХАМГААЛБЯ” өдөрлөгийг Төв цэнгэлдэх хүрээлэнд зохион байгуулсан. Тус өдөрлөгт хүрэлцэн ирсэн хүүхэд багачуудад зориулж цагдаагийн байгууллагад ашиглагдаж байсан болон одоо ашиглаж байгаа автомашин, техник хэрэгслийн үзэсгэлэн, цагдаагийн виртуал музейн үзмэр, Онцгой байдлын ерөнхий газрын шүхэртэй үзүүлбэр, “Ногоон гэрэл, цагаан шугам” тэмцээнийг оролцогч хүүхдүүдийн үзүүлэх тоглолт, хүүхэд, багачуудад зориулсан урлагийн тоглолт, Дотоод хэргийн их сургуулийн сонсогчдын гардан тулааны үзүүлбэр, Цагдаагийн байгууллагын албаны нохойн болон Тусгай ажиллагааны тактикийн үзүүлэх тоглолтуудыг сонирхуулсан нь иргэн-цагдаагийн хамтын ажиллагааг бэхжүүлэх арга хэмжээ болсон.

Урин дулаан цагт иргэд, хөдөө орон нутаг руу олноор зорчих, зам тээврийн осол, хэргийн улмаас иргэдийн амь нас, эд хөрөнгө хохирохоос урьдчилан сэргийлэх, хөдөлгөөнд оролцогчдын буруу дадал, хандлагыг өөрчлөх, зөв үйлдэлд уриалах чиглэлээр “Аажуу явбал аяндаа хүрнэ дээ” арга хэмжээг зохион байгуулснаар зам тээврийн ослын шинжтэй дуудлага, мэдээлэл өмнөх оны мөн үеэс 266 нэгжээр буюу 19.8 хувиар, бүртгэгдсэн зам тээврийн осол 22 нэгжээр буюу 22.4 хувиар, нас барсан хүний тоо 2 нэгжээр буюу 15.4 хувиар, гэмтсэн хүний тоо 25 нэгжээр буюу 36.8 хувиар, хүүхэд өртсөн осол 8 нэгжээр буюу 36.4 тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, иргэдийн санхүүгийн болон хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, энэ төрлийн гэмт хэргийн талаарх ойлголт мэдлэгийг өгөх зорилгоор “Залилах” арга хэмжээг улсын хэмжээнд зохион байгуулж, 71 телевизээр иргэд, олон нийтэд мэдээлэл өгч, хэлэлцүүлэг явуулж, 25 мэдээллийн сайтад зорилтот нийтлэл хэвлүүлж, нийт 18 постер, 12 видео шторк, 13 подкаст, лайв бэлтгэн цахим орчинд түгээлт хийсэн нь давхардсан тоогоор 6.365.847 хүнд хүрээд байна.

Монгол Улсад аялал, жуулчлалын салбарыг дэмжих, жуулчдын аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор улсын хэмжээнд энэ оны 06 дугаар сарын 20-ны өдрөөс 08 дугаар сарын 10-ны өдрийн хооронд Дотоод хэргийн их сургуулийн сонсогч, гадаад хэлний сургалттай их, дээд сургуулийн оюутнуудыг “Оюутан цагдаа”-гаар ажиллуулж эхлээд байна. “Оюутан цагдаа” нар гэмт хэргийн шинжтэй 91, зөрчлийн шинжтэй 412 дуудлага, мэдээлэл хүлээн авч, 14 гэмт хэрэг, 164 зөрчлийг илрүүлэн нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагад шилжүүлж, дотоодын 16989, гадаадын 2171 иргэнд хэлмэрчилэн, туслалцаа үзүүлж, зурагт хуудас, зөвлөмж, сэрэмжлүүлэг 36296 ширхгийг тарааж, эцэг, эх, асран хамгаалагчаасаа төөрсөн бага насны 83 хүүхдийг ар гэр, асран хамгаалагчид нь хүлээлгэн өгсөн байна.

Цар тахлын үед төр засгаас хэрэгжүүлж буй бодлого шийдвэрийг иргэдэд хүртээмжтэй байдлаар хүргэх, тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, байгууллагын үйл ажиллагааг сурталчлах чиглэлээр [mbg.police.gov.mn](http://mbg.police.gov.mn) цахим хуудсанд мэдээлэл 35, постер 10, видео 8, фото 18, нийт 71 сэрэмжлүүлэг мэдээллийг байршуулсныг давхардсан тоогоор 981.230 хэрэглэгч үзэж, 812 хүн бусдад хуваалцсан байна.

Хулгайлах, залилах, цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр “TV6”, “Eagle” телевизэд 13 ярилцлага, “News.mn”, “Arslan.mn”, “Etoim.mn” сайтад 4 видео, 6 ярилцлага, Цагдаагийн ерөнхий газрын Хэвлэл мэдээллийн төвөөс бэлтгэн явуулдаг “Амрыг эрье” нэвтрүүлэгт 4 удаагийн ярилцлага, мэдээлэл тус тус өгч, олон нийтэд хүргэсэн.

**2.2.Гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр:** Хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх, эрэн сурвалжлагдаж байгаа сэрдэгдсэн болон оргодол этгээдүүдийг олж тогтоох зорилгоор “Сар шинэ-2022”, “Хуурамч мөнгө”, “Түлхүүр”, “Хувьцаа”, “Хуурамч акц” зэрэг 5 удаагийн нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг улс, нийслэлийн хэмжээнд зохион явуулж, үр дүнг тооцсон.

Цагдаагийн байгууллагын хэмжээнд сүүлийн 3 жилийн байдлаар гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд, иргэн хохирсон, холбогдсон хэргийн судалгааг гаргаж, гадаадын иргэн хохирсон 101, холбогдсон 19, нийт 120 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулснаас 16 хэргийг шүүхэд шилжүүлж, 3 хэргийг бусад хэрэгт нэгтгэн, хэрэг бүртгэлтийн 23 хэргийг хаах саналтай прокурорын байгууллагад шилжүүлэн мөрдөн байцаалтын шатанд 5.89 тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, 6.85 тэрбум төгрөгийн хөрөнгийг битүүмжлэн, үлдэгдэл 78 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна.

Мөрдөн шалгах ажиллагааны явцад нуугдмал өмч, хөрөнгийг илрүүлэх, хохирлыг нөхөн төлүүлэх ажлыг эрчимжүүлж ажилласнаар гэмт хэргийн улмаас иргэн, хуулийн этгээдэд 1136.6 тэрбум төгрөгийн хохирол учирснаас 604.0 тэр бум төгрөг буюу 53.1 хувийг нөхөн төлүүлж, 137.8 тэрбум төгрөгийн эд хөрөнгийг битүүмжилсэн. Хохирол нөхөн төлүүлэлт өмнөх оны мөн үеэс 3.2 хувиар өссөн байна.

Эрүүгийн цагдаагийн албаны харьяа нэгжүүдэд өссөн дүнгээр иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 28402 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 25094 буюу нийт гомдол мэдээллийн 88.3 хувийг шийдвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 40.4 хувиар өссөн.

Эрүүгийн цагдаагийн албаны хэмжээнд 2022 оны эхний 6 сарын байдлаар нийт 31696 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулснаас 6849 /21,6%/ хэргийн эзэн холбогдогчийг олж тогтоон яллагдагчаар татах саналтай мөрдөн байцаалтад, 5153 /16,2%/ хэргийг хаах, 432 /1,3/ хэргийг харьяаллын дагуу шилжүүлэх, 107 хэргийг нэгтгэх саналтай тус тус прокурорт шилжүүлж, нийт хэргийн 12541 буюу 39,5 хувийг шийдвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 6.5 хувиар өссөн.

Эрэн сурвалжлах “ASAP” сангаар эрэн сурвалжлагдаж байсан эрүүгийн хэргийн оргодол 83, гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд 121, оршин суугаа газраасаа сураггүй алга болсон хүн 28, Хорихоос өөр төрлийн ял шийтгэгдсэн хүн 38, хэн болох нь тогтоогдохгүй цогцос 1, Шүүхээс даалгасан 22 хүнийг тус тус эрэн сурвалжлан олж тогтоож, нийт 293 эрэн сурвалжлалтыг зогсоон.

**2.3.Экологийн цагдаагийн албаны чиглэлээр:** Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр Лондонгийн амьтан судлалын нийгэмлэг /ZSL/-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газартай хамтран “Монголын Экологийн цагдаа: Дэлхийн жишгээр ажиллаж, иргэдтэй түншлэх нь” төслийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Улсын хэмжээнд 2022 оны эхний хагас жилд хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй нийт 1099 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь өмнөх оны мөн үеэс бүртгэгдсэн гомдол 118 буюу 12.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг энэ оны эхний 06 сард нийт 293 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 22 хэргээр буюу 8.1 хувиар өссөн үзүүлэлттэй, улсын хэмжээнд бүртгэгдсэн 20125 хэргийн 1.5 хувийг эзэлж, хэргийн илрүүлэлт **35.3** хувьтай байна.

Бүртгэгдсэн 293 хэргийн 272 буюу 92.8 хувь нь орон нутагт, 21 буюу 7.2 хувь нь нийслэлд бүртгэгдсэнийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад орон нутагт бүртгэгдсэн хэрэг 26 буюу 10.6 хувиар өсөж, нийслэлд бүртгэгдсэн хэрэг 4 буюу 16.0 хувиар буурсан байна.

Энэ төрлийн гэмт хэргийн улмаас нийт 246 иргэн, 6 хуулийн этгээдэд 1.805.837.852 төгрөгийн хохирол учирснаас 871.604.061 төгрөгийг буюу 48.3 хувийг нөхөн төлүүлж, 466.845.903 төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн байна.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйл “Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны харьяалал”-ийн 1.8.6.8 дахь хэсэгт цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч Зөрчлийн тухай хуулийн 7.15 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт заасан зөрчлийг шалгах эрхтэй талаар заасан бөгөөд 2022 оны эхний 06 сард Зөрчлийн тухай хуулийн 7.15.8 дахь хэсгээр улсын хэмжээнд 49 зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 8 зөрчлөөр буюу 19.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, шийдвэрлэлтийг ахиулах, энэ төрлийн гэмт хэрэг үйлдэж болзошгүй этгээдүүдийг хяналтад авах зорилгоор “Эко-2022” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулснаар 125 холбогдогчтой 1.129.300.000 төгрөгийн хохиролтой, 98 хэрэг, үйлдлийг илрүүлэн цагдаагийн байгууллагын гомдол, мэдээллийн санд бүртгэн 118.700.000 төгрөгийг нөхөн төлүүлж, археологийн олдвор болох бүтэн динозаврын яс 1, хууль бусаар агнасан тэх 1, хулан 3, хүрэн баавгай, цоохор ирвэс, шилүүсний арьс тус бүр 1, андаторын арьс 27, хүдрийн заар 15, шаазгай 3, хойлог шувуу 3, загас 524, цагаан зээр 2, нийт 406 тооны амьтны гаралтай эд эрхтэн, хууль бусаар бэлтгэсэн 164.8 куб.метр мод, манж гандигр ургамал 25, хонин арц 218, нийт ховор 243 кг ургамал, алтны агууламжтай чулуу 980 кг, тэсрэх бодис 25 ширхэг, жонш 400 тонныг тус тус хураан авч, 5 тээврийн хэрэгсэл, 1 металл хайгч, 12 экскаватор, 23 хөрөөг битүүмжлэн мөрдөн шалгах ажиллагаа явуулсан.

Мөн иргэн бүрд байгаль дэлхийгээ шүтэн хамгаалж, байгаль орчинтойгоо зохицон амьдарч ирсэн үндэсний өв уламжлалаа шинжлэх ухаан, инновац, технологийн ололтод тулгуурлан, тогтвортой хөгжлийн төлөөх үзэл баримтлалаар баяжуулан бүх нийтийн экологийн боловсролыг дээшлүүлэх, байгаль орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх шинэ үеийн нэгдмэл үзэл, төлөвшил, байгаль хамгаалах зөв дадал хандлагыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор 2020-2023 онд хэрэгжүүлэх “Байгаль эн тэргүүнд” төслийг боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд энэ оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс 05 дугаар сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас “Байгалиа хамгаалъя-Ногоон дуу хоолой” нөлөөллийн аяныг улсын хэмжээнд “Зөв мод-Зөв арчилгаа” уриатайгаар зохион байгуулсан.

Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2022 оны хаврын улирлын тарилтыг улс, орон даяар зохион байгуулах, мод тарих соёлыг түгээн дэлгэрүүлэх, соён гэгээрүүлэх, олон нийтэд сурталчлан таниулах зорилготой мэдээлэл сурталчилгааны ажлын хүрээнд 110 мэдээлэл бэлтгэн цахим орчинд байршуулсныг 114.462 хүн дэмжиж, 12.509 хүн эерэг сэтгэгдэл үлдээж, 130.154 хүн бусдад түгээсэн нь давхардсан тоогоор 14.265.656 хүнд хүрч иргэдийг мод тарихад уриалсан, мод тарих, ургуулах соёлыг дэлгэрүүлсэн, хандлага мэдлэг ойлголтыг нэмэгдүүлсэн, буруу дадал хандлагад эерэгээр нөлөөлсөн, зөв үйлдэлд уриалж сэдэлжүүлсэн арга хэмжээ болсон.

**2.4.Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр:** Улсын хэмжээнд давхардсан тоогоор 29788 офицер, 51628 цагдаа, нийт 81416 алба хаагч эргүүлийн үүрэг гүйцэтгэж, 79518 объект, 411209 хүн, 251375 тээврийн хэрэгсэл шалгаж, гэмт хэрэг зөрчлийн 174522 дуудлага, мэдээллийг шалгаж, 83 хэрэг, 43558 зөрчлийг илрүүлэн, 45519 иргэн, 194 хуулийн этгээд, албан тушаалтанд 1,396,359,500 төгрөгийн торгууль оногдуулан, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 749, түр саатуулсан 751 тээврийн хэрэгсэл, 12054 хүнийг ар гэрт нь хүлээлгэн өгч, 415 хүнийг шүүхийн шийдвэрээр баривчлуулж ажилласан.

Эргүүлийн нэгдсэн байршилтыг гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгддэг эмзэг цэгийн судалгаанд үндэслэн улсын хэмжээнд авто эргүүлийн 130 чиглэлд 260 алба хаагч, явган эргүүлийн 816 чиглэлд 1632 алба хаагч, морьт эргүүлд 236 чиглэлд 472 алба хаагч, нисдэг дронт эргүүлд 266 чиглэлд 532, улсын хэмжээнд нийт 1448 чиглэлд 2896 алба хаагч ажиллуулж байна.

Гудамж, талбай, олон нийтийн газарт үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр эхний хагас жилд Баянгол, Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт “Эргүүл” тусгай арга хэмжээ, Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт, “Авто болон явган эргүүл” тусгай арга хэмжээг тус бүр 1 сарын хугацаанд зохион байгуулснаас Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт зохион байгуулсан тусгай арга хэмжээний үр дүнд тухайн сард гэмт хэргийн шинжтэй дуудлага, мэдээлэл 11.8, халаасны хулгайн гэмт хэрэг 29.8 хувиар тус тус буурсан эерэг үр дүн гарсан.

Цагдаагийн байгууллагаас улсын хэмжээнд шүүхээс тэнсэн суллагдсан 277, хорих ялаас тэнсэн суллагдсан 182, насанд хүрээгүй этгээдэд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан 2, жирэмсэн, 3 хүртэлх настай хүүхэдтэй эх, ганц бие эцэгт хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан 2, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэсэн 10, хорих ял эдлээд суллагдсан 174, нийт 647 хүнд өнөөдрийн байдлаар хяналт тогтоон ажиллаж байна.

Улсын хэмжээнд согтуугаар үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Зөвийг зөвлөө” арга хэмжээг зохион байгуулсан.

Арга хэмжээний хүрээнд иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, архины зохисгүй хэрэглээг багасгах, тэднийг зөв үйлдэлд уриалах чиглэлээр төрийн 596, төрийн бус 1223 байгууллагатай хамтран 543 удаагийн сургалт нөлөөллийн арга хэмжээг зохион явуулж, 64600 иргэдийг хамруулж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн газар, хэлтсээс арга хэмжээг иргэд олон нийтэд шинэлэг, хүртээмжтэй хэлбэрээр хүргэх чиглэлээр аймаг, дүүрэг дэх Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд холбогдох саналыг хүргүүлж, нийт 41.812.250 төгрөгийн зардлыг шийдвэрлүүлсэн.

Мөн 9229 төрлийн 44844 ширхэг зурагт хуудсыг сургалт нөлөөллийн арга хэмжээний үеэр иргэдэд тарааж, согтууруулах ундааны хор уршгийг таниулж, иргэн, хуулийн этгээдэд 994 төрлийн мэдэгдэл, шаардлага хүргүүлэн, 1099 биелэлтийг шалгаж, 1621 иргэн, 9 хуулийн этгээдэд 48,718,558 төгрөгийн торгох шийтгэл оногдуулсан.

Арга хэмжээг улсын хэмжээнд гудамж талбайн хулдаасан хэвлэл 485, аж ахуйн нэгж байгууллага орон сууцны 320, гудамж талбайн 780 лед дэлгэцэд 28 төрлийн видео шторк байрлуулан иргэд, олон нийтэд сурталчилж, төв, орон нутгийн 26 телевизийн зочны цагаар давхардсан тоогоор 105 удаа, 17 фм радио, 28 сонин,

36 цахим сайт /пейж/-д давхардсан тоогоор 1609 мэдээ, мэдээллийг байршуулан, хамтран ажилласан.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2021 оны 196 дугаар захирамж, Засгийн газрын 2022 оны “Замын-Үүдийн авто боомтод авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” 27 дугаар тогтоолын дагуу “Эрээн-Замын-Үүд” боомтоор давхардсан тоогоор нийт 8016 тээврийн хэрэгслээр 40 тонн чингэлэг 5860 ш, 20 тонн чингэлэг 4263 ш нийт 10123 чингэлэг ачааг гаалийн хяналтын бүс рүү хүргэх, буцах үеийн хамгаалалтад давхардсан тоогоор цагдаагийн байгууллагын 2805 алба хаагч 495 тээврийн хэрэгсэлтэй зохион байгуулан ажиллаж байна.

Монгол Улсын хэмжээнд 2022 оны эхний 6 сарын байдлаар 21 аймгийн 532 дүүрэг, сумын 1136 хороо, багийн хорио цээрийн 21718 голомтод бүсэд бог мал 844967, бод мал 831911, хээрийн зэрлэг амьтан 25, мал, амьтны гоц халдвар шүлхий, мялзан, ям, боом, галзуу, цэцэг өвчнөөр өвчлөх үед, хүчтэй салхи шуурга 11, Объектын гал түймэр 244, Хээрийн гал түймэр 46, Бичил уурхайн осол 4, төөрсөн сураггүй алга болсон иргэн 12, газар хөдлөлтийн 2 удаагийн осол болох үеийн хэв журам сахиулах хамгаалалт, зохицуулалтад давхардсан тоогоор цагдаагийн байгууллагаас 4138 алба хаагч, 1662 тээврийн хэрэгсэлтэй, бусад байгууллагын 10292 алба хаагч тус тус үүрэг гүйцэтгэж ажилласан.

Төв, орон нутагт зохион байгуулагдсан 620 удаагийн нийтийг хамарсан арга хэмжээний хамгаалалтад давхардсан тоогоор 16321 алба хаагч, 2468 автомашин, 16528 тусгай хэрэгсэлтэйгээр 192,649,28 цагийн үүрэг гүйцэтгэж 257,417 орчим иргэдийн аюулгүй байдлыг хангаж ажилласан.

Улс төрийн нам, иргэний хөдөлгөөн, холбоо, төрийн бус байгууллага, иргэд, олон нийтийн зүгээс 164 удаагийн буюу 1703 цаг үргэлжилсэн жагсаал, цуглаан, эсэргүүцлийн арга хэмжээ зохион байгуулагдаж, давхардсан тоогоор 313.659 орчим иргэн оролцох үед цагдаагийн байгууллагаас давхардсан тоогоор 2890 алба хаагч үүрэг гүйцэтгэсэн.

Гадаадын дипломат төлөөлөгчийн 18 газрын 21 харуулын цэг, Нэгдсэн Үндэстний Байгууллагын суурин төлөөлөгчийн газрын 1, Оюуны өмч улсын бүртгэлийн ерөнхий газрын 4, Үнэт цаас төвлөрсөн хадгаламжийн төвийн 1, Монгол банкны 15, нийт 41 харуулын цэгээр нэвтрэх үнэмлэхтэй 27290 иргэн, явганаар 4806, тээврийн хэрэгсэлтэйгээр 5140 иргэн, нийт 39879 удаагийн орж, гарах хөдөлгөөнд хяналт тавьж, шалган нэвтрүүлэхэд зөрчил дутагдал илрээгүй.

Төр засгийн тэргүүнүүд төрийн ёслол хүндэтгэлийн арга хэмжээнд оролцох, нийслэл хот, төв орон нутагт товлосон объектод ирэх, буцах үеийн хамгаалалт, зохицуулалт, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр нийт 931 удаагийн хамгаалалтад давхардсан тоогоор 6548 алба хаагч, 1068 автомашинтай, 28632.6 хүн/цагийн үүрэг гүйцэтгэсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны “Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай” 62 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд цагдаагийн байгууллагаас шалган нэвтрүүлэх цэгийн болон эргүүл хяналт, шалгалт гэсэн 2 хэлбэрээр зохион байгуулан ажиллаж байна.

Шалган нэвтрүүлэх цэгийн хяналтаар агаарын чанарыг сайжруулах бүсэд дулаан үйлдвэрлэх, түгээх, зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөлтэй 17 аж ахуйн нэгж байгууллагын 170 зууханд хэрэглэгдэх 2272 тээврийн хэрэгслээр 54049.67 тонн түүхий нүүрс, агаарын чанарыг сайжруулах бүсээр дамжин өнгөрсөн түүхий нүүрс 708 тээврийн хэрэгслээр 26953.12 тонн, баяжуулсан нүүрс 166 тээврийн хэрэгслээр 7125.85 тонн, “Таван толгой түлш” ХХК-ийн түүхий эд 6300

тээврийн хэрэгслээр 252560.7 тонн татан авалтад хяналт тавьж, зөвшөөрөлгүй түүхий нүүрс тээвэрлэсэн 5, сайжруулсан шахмал түлш тээвэрлэсэн 20 зөрчлийг илрүүлэн, мэргэжлийн хяналтын байгууллагад шилжүүлж 25 иргэнийг 2.5 сая төгрөгийн торгуулын арга хэмжээг тооцуулж, 479 шуудай шахмал түлш, 95 тонн түүхий нүүрсийг хурааж, Амгалан дулааны станцад төвлөрүүлэн улсын орлого болгуулсан.

**Зөрчил шалган шийдвэрлэх чиглэлээр:** Цагдаагийн байгууллагын хэмжээнд 160837 гомдол, мэдээлэл хүлээн авч, шалгаснаас 110062 буюу 68.4 хувийг зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл эзэлж байна.

Бүртгэгдсэн зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 108328 буюу 98.4 хувийг шийдвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 23448 нэгж буюу 27.6 хувиар өссөн эерэг үзүүлэлттэй байна. Үүнээс зөрчлийн хэрэг нээж, хялбаршуулсан журмаар торгосон 79774 буюу 73.6, зөрчлийн хэрэг нээхээс татгалзсан 27807 буюу 25.6, харьяаллын дагуу шилжүүлсэн 747 буюу 0.6 хувийг шийдвэрлэсэн байна.

Улсын хэмжээнд 1.436.323 зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 704.719 буюу 96.3 хувь өссөн. Орон нутагт 305.040 буюу 21.2, нийслэлд 1.131.283 буюу 78.7 хувь нь бүртгэгдсэн. Зөрчлийн шийдвэрлэлтээр нь авч үзэхэд: торгосон 1.400.187 буюу 97.4, шүүхийн шийдвэрээр баривчлуулсан 9010 буюу 0.6 хувь, торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хассан 23654 буюу 1.6 хувь байна.

Монгол Улсад Зөрчлийн болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн өдрөөс хойших буюу сүүлийн 5 жилийн хугацаанд нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад цуглараад байгаа “Зөрчлийн хэрэг”, “Зөрчлийн талаарх гомдол мэдээлэл хүлээн авахаас татгалзсан”, “Хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэсэн” хэрэг, материалыг, хадгаламжийн нэгж үүсгэн хадгалах хугацааг тогтоох талаар Улсын ерөнхий прокурор, Эрүүгийн хэргийн Төв архив, Улсын төв архивын холбогдох албан тушаалтнуудтай холбогдон, архивын журамд нэмэлт, өөрчлөлт оруулах талаар судалгааг хийсэн.

**2.5.Тээврийн цагдаагийн албаны чиглэлээр:** Улсын хэмжээнд энэ оны эхний 06 сарын байдлаар нийт 318.904 дуудлага, мэдээлэл хүлээн авсны 57.099 буюу 17.9 хувь нь зам тээврийн ослын шинжтэй, 218 нь төмөр замын аюултай бүс, зурвас газар болон төмөр замын байгууллага, аж ахуйн нэгжийн нутаг дэвсгэрт, 135 нь нисэх онгоцны буудлын аюултай бүс, зурвас газар болон харьяа байгууллага, аж ахуйн нэгжийн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн дуудлага, мэдээлэл байна. Хүлээн авсан зам тээврийн ослын шинжтэй дуудлага мэдээллийн 54.401 буюу 95.3 хувь нь нийслэлд, 2684 буюу 4.7 хувь нь орон нутагт гарсан байна. Дуудлага, мэдээллийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 54.6 хувиар өссөн байна.

Цагдаагийн байгууллага 2022 оны эхний 06 сарын байдлаар иргэд, байгууллага аж ахуйн нэгжээс нийт 160.837 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаж шийдвэрлэснээс 45.474 буюу 28.3 хувь Хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг гомдол, мэдээлэл байна. Хүлээн авсан гомдол, мэдээллийн 27.495 буюу 60.5 хувийг нийслэлд, 18.252 буюу 39.5 хувийг орон нутагт шалгаж шийдвэрлэжээ. Нийт шийдвэрлэсэн гомдол мэдээллийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 71.6 хувиар өссөн.

Иргэд аж ахуйн нэгж байгууллагаас гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 1514 гомдол мэдээлэл хүлээн авч шалгаснаас 1384 гомдол мэдээлэл буюу 91.4 хувийг шалгаж шийдвэрлэсэн байна.

Тайлангийн хугацаанд нийт 11.910 зам тээврийн осол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 43.8 хувиар өссөн нь нийт ослын 10.251 буюу 86.1 хувь нийслэлд, 1659 буюу 13.9 хувь нь орон нутагт бүртгэгджээ.

Цагдаагийн байгууллагад эхний хагас жилийн байдлаар 20.125 хэрэг бүртгэгдсэнээс 574 хэрэг нь Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг байна.

Автотээврийн хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 572 бүртгэгдэж, 133 хүн нас барж, 498 хүн гэмтсэнийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад гэмт хэрэг 82.2, гэмтсэн хүн 85.8, нас барсан хүн 66.3 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Мөн хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг 285 гэмт хэргээс 75 хэрэгт мөрдөн байцаалтын хэрэг, 210 хэрэгт хэрэг бүртгэлтийн хэрэг нээж шалгасан.

Улаанбаатар хотын хэмжээнд шинээр байрлуулах 335, арчлалт, засвар хийлгэх 164, хурааж авах 14 тэмдгийн судалгааг байршил, зураглалын хамт гаргаж Нийслэлийн замын хөгжлийн газарт хүргүүлсэн.

Тайлангийн хугацаанд улсын хэмжээнд бүртгэгдсэн зам тээврийн осол, хэргийн товч мэдээлэл, шалтгаан, нөхцөл, хор уршгийг таниулах, иргэдийн хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор долоо хоног, амралтын өдрүүдийн нөхцөл байдлын мэдээ, сэрэмжлүүлэг зэргийг бэлтгэн давхардсан тоогоор өргөн нэвтрүүлгийн 41 телевизэд 191 төрлийн мэдээллийг 415 удаа, 10 ФМ радиод 102 төрлийн мэдээллийг 149 удаа, 132 цахим сайтад 132 төрлийн 1290 минутын мэдээллийг 430 удаа тус тус өгч иргэд, олон нийтэд сурталчилсан.

Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох зөрчлийг бууруулах, таслан зогсоох, хүүхдийг зам тээврийн осол хэрэгт өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх зорилгоор “Уусан бол бүү жолоод”, “Гэрлээр анхааруулъя”, “Гар утас”, “Тавхан хором хүлээе”, “Сурагчийн аюулгүй байдалд эцэг эх, асран хамгаалагчийн үүрэг оролцоо 2022” урьдчилан сэргийлэх 5 төрлийн нэгдсэн арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна.

**2.6.Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны чиглэлээр:** Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэхийг судлан үзэх эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас ирүүлсэн 154 албан бичгийн дагуу 4895 хүн, 23 хуулийн этгээд, “Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэхийг шалгах хуудас”-аар 804 хүнийг тус тус шалган хариу өгч, иргэдийн хүсэлтээр 2660, хуулийн этгээдийн хүсэлтийн дагуу 56, нийт 2716 тодорхойлолт олгон, ялтны хувийн хэргээс хуулбар авах тухай 431 албан бичгээр 444 хүнд холбогдох 629 хувийн хэргээс 8460 хуудас материалыг хуулбарлаж өгсөн.

Цагдаагийн байгууллагын нэгдсэн сангийн гомдол, мэдээллийн болон гэмт хэрэг, зөрчлийн мэдээллийн санг 32 төрлийн 1.829.066 нэгж мэдээллээр баяжуулж, сар бүр 23 нэр төрлийн нийт 138 статистик, мэдээ тайланг боловсруулан гаргаж, холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, цагдаагийн байгууллагын дотоод [/guide.police.gov/](http://guide.police.gov/) сүлжээ, гадаад [/police.gov.mn/](http://police.gov.mn/), <http://information.police.gov.mn/> цахим сайтуудад байршуулсан. Эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас ирүүлсэн 87 албан бичгийн дагуу 2106 иргэн, 10 хуулийн этгээдийг эрүүгийн хариуцлагад татагдсан болон гэмт хэрэг, зөрчилд холбогдон шалгагдсан эсэх талаарх лавлагааны хариуг албан бичгээр хүргүүлсэн.

Мөн Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй төрийн үйлчилгээг цахимжуулах, цагдаагийн байгууллагын үйлчилгээг иргэд, олон нийтэд түргэн



шуурхай хүргэж, мэдээллийн дэвшилтэт технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх чиглэлээр “E-Mongolia” нэгдсэн системээр дамжуулан 7 төрлийн лавлагаа, 5 төрлийн үйлчилгээ, 10 төрлийн зөвшөөрөл олгох үйлчилгээ үзүүлж байна.

**Бүртгэгдсэн гэмт хэргийг төрлөөр нь авч үзвэл:** Монгол Улсад үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийн хэтийн төлвийг тодорхойлох зорилгоор Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн судалгааны багтай хамтран “Т-21” систем динамикийн загварчлалыг боловсруулж, туршилтаар ашиглаж байна.

2022 оны эхний 06 сарын байдлаар цагдаагийн байгууллагад нийт 160.837 гомдол, мэдээлэл бүртгэгдэн шалгагдсаны 50.775 буюу 31.6 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 110.062 буюу 68.4 хувь нь зөрчлийн шинжтэй байгааг өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт бүртгэгдсэн гомдол мэдээлэл 45526 буюу 39.5, гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 21545 буюу 73.7, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 23981 буюу 27.9 хувиар өссөн байна.

Гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 15835 буюу 31.2 хувьд нь хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 30312 буюу 59.7 хувьд нь хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзан, 382 буюу 0.7 хувийг нь харьяаллын дагуу шилжүүлж, шийдвэрлэсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 6359 буюу 16.7 хувийг 5 хоногт, 39400 буюу 84.7 хувийг 6-19 хоногт шийдвэрлэсэн.

Улсын хэмжээнд нийт 20125 гэмт хэрэг бүртгэгдсэний 13807 буюу 68.6 хувь нь нийслэлд, 6315 буюу 31.3 хувь нь орон нутагт, 3 буюу 0.1 хувь нь бусад газарт /хилийн чанадад/ бүртгэгдсэнийг өмнөх онтой харьцуулахад гэмт хэрэг 9530 буюу 89.9 хувиар, нийслэлийн хэмжээнд 7092 буюу 2.1 дахин, орон нутагт 2447 буюу 63.3 хувиар өсөж, бусад газар /хилийн чанадад/-т 9 буюу 75.0 хувиар буурсан.

Хулгайлах гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс 2.5, дээрэмдэх гэмт хэрэг 2.4, залилах гэмт хэрэг 2.6, хүүхдийн эсрэг гэмт хэрэг 2.1, мал хулгайлах гэмт хэрэг 48.5, хүчиндэх гэмт хэрэг 61.4, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 45.4 хувиар өсөж, олон нийтийн аюулгүй байдал ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 45.2 хувиар буурч, цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг өмнөх оны мөн үеийн түвшинд байна.

Гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд 48.7 хувь, нийслэлд 48.9 хувь, орон нутагт 48.3 хувь байгаа нь өмнөх оны мөн үеэс улсын хэмжээнд 4.5, нийслэлд 5.5, орон нутагт 1.9 нэгжээр өссөн байна.

Гэмт хэргийн улмаас 40 хуулийн этгээд, 19973 иргэн хохирсноос 376 хүн нас барж, 5505 хүн гэмтсэнийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт хохирогч 9714 буюу 94.7 хувиар, гэмтсэн хүн 1839 буюу 50.2 хувиар, нас барсан хүн 96 буюу 34.3 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

**Мэдээлэл хүлээн авах, шуурхай удирдлагын чиглэлээр:** Улсын хэмжээнд гэмт хэрэг, зөрчлийн 279.669 дуудлага, мэдээлэл хүлээн авснаас гэмт хэргийн 8744, зам тээврийн осол, хэргийн 60603, зөрчлийн 183.122, хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн 24.396 /үүнээс: сураггүй алга болсон хүн, хүүхэд 2072, олдсон хүн, хүүхэд 732/, бусад 216 бүртгэгдсэн ба үүнээс: гадаадын иргэнтэй холбоотой 213, архидан согтуурсантай холбоотой 84.562, цагдаагийн алба хаагчтай холбоотой 475, хар тамхи, мансууруулах бодистой холбоотой 20 мэдээ, мэдээлэл бүртгэгджээ.

Төв, орон нутаг дахь цагдаагийн газар, хэлтсүүдийн нөхцөл байдал, тусгай дугаарын утсанд ирсэн онцлог мэдээллүүдийг Цагдаагийн ерөнхий газрын Онцгой нөхцөл байдлын шуурхай удирдлага, зохицуулалтын хэлтэст 8355 мэдээлэл,

Эрүүгийн цагдаагийн албаны жижүүрт 336 мэдээлэл, Мөрдөн байцаах албаны жижүүрт 298, Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Дотоод аюулгүй байдлын хэлтэст 269 мэдээллийг дамжуулж ажилласан.

Тусгай дугаарын 102 утсанд бүртгэгдсэн хулгайн 633, хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн 7178 дуудлагын шийдвэрлэлт, очсон хугацаанд хяналт тавьж, хулгайлах гэмт хэргийн дуудлага өгсөн 3505, хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн дуудлага өгсөн 21034, сураггүй алга болсон гэж бүртгүүлсэн хүн, хүүхдийн талаар мэдээлэл өгсөн 6115, нийт 30654 иргэнтэй холбогдож ажилласан байна.

Тусгай дугаарын утсанд бүртгэгдсэн гэмт хэрэг, хэв журмын зөрчил, согтуу, зам тээврийн ослын нийт 234 дуудлага, мэдээлэлд хяналтын камер, дэлгэцийн систем ашиглан хяналт тавьж, холбогдох албан тушаалтнуудад мэдэгдэж ажилласан.

**2.7.Архивын үйл ажиллагааны чиглэлээр:** Архив, албан хэрэг хөтлөлтийн “EDOC” программ хангамжийг Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын хэмжээнд бүрэн нэвтрүүлсэн.

Хөмрөг үүсгэгч 5 байгууллагаас байнга хадгалах 256, боловсон хүчний 70 жил хадгалах 12, боловсон хүчний хувийн хэрэг 36, нийт 304 баримт, Тусгай санд хөмрөг үүсгэгч 2 байгууллагаас төрийн нууцад хамаарах 109 баримтыг тус тус нягтлан шалгаж, дугаар олгон хадгаламжийн санд байрлуулсан.

Цаасан суурьтай баримтыг лавлагаа, мэдээлэл, уншлагын танхим, судалгаа, эрдэм шинжилгээ, нягтлан шалгалтад зориулж 49 хөмрөгийн 54 данс бүртгэлийн 1134 хадгаламжийн нэгжийн 228088 хуудас баримтыг бүртгэлийн дагуу олгож, ашиглуулсан.

Монгол Улсад Дотоодын цэрэг үүсэж хөгжсөний 100 жилийн ойг тохиолдуулан “Монгол Улсын Дотоодын цэргийн түүх”, “Монгол Улсын Дотоод цэргийн түүхэн баримт бичгийн эмхэтгэл” ном бүтээх ажлын хүрээнд Үндэсний Төв архивын сан хөмрөгөөс 318 хадгаламжийн нэгжийн 679 хуудас баримтыг хуулбарлан авахаар бэлтгэсэн байна.

Цагдаагийн байгууллагын албан ёсны [www.police.gov.mn](http://www.police.gov.mn) сайтад байгууллага, алба хаагч, аян арга хэмжээтэй холбоотой 41 ярилцлага, цаг үе, үйл явдлын 98, видео мэдээ 21, бусад 42 нийт 202 мэдээ, мэдээллийг бэлтгэн байршуулсан нь давхардсан тоогоор 2.917.854 хүний хандалт авсан байна.

Хэвлэл, мэдээллийн төвийн фэйсбүүк цахим хуудаст цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын онцлог үйл явдал, аян арга хэмжээ, ярилцлага, мэдээ мэдээлэл 870-г бэлтгэн иргэд, олон нийтэд түгээж ажилласан. Мэдээ, мэдээлэл, ярилцлага, постерыг давхардсан тоогоор 13.220.621 хүн үзэж, 421.823 хүнд таалагдаж, 31.251 удаа хуваалцаж, 21.621 удаа сэтгэгдэл үлдээсэн байна. Твиттер хуудаст 98 мэдээ, мэдээллийг байршуулан ажилласан.

Хэвлэл, мэдээллийн төвийн фэйсбүүк цахим хуудаст иргэдээс ирүүлсэн гэмт хэрэг зөрчлийн, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаар нийт 1859 санал, хүсэлтэд хариулт, хууль зүйн зөвлөгөө өгч, 35 мэдээллийг холбогдох байгууллага руу шалгуулахаар шилжүүлсэн.

Фэйсбүүк хуудас 216.147 дагагчтай байгаагаас өдөрт дунджаар 169.187 хүн хандаж, мэдээ мэдээлэл авч байна.

Тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, цаг үеийн нөхцөл байдал, байгууллагын үйл ажиллагааг сурталчлах чиглэлээр давхардсан тоогоор 956 хэвлэл, мэдээллийн байгууллагатай хамтран ажиллаж, тодруулга мэдээлэл өгч,

гэмт хэргийн шалтгаан нөхцөлд хийсэн судалгаа, дүн шинжилгээнд үндэслэн 48 удаагийн нэвтрүүлэг, 56 удаагийн гэмт хэргийн мэдээ, 36 удаагийн урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээлэл бэлтгэн түгээх ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулсан.

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагаас зохион байгуулж байгаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан аян, арга хэмжээний хүрээнд энэ оны эхний хагас жилийн байдлаар “Амрыг эрье” нэвтрүүлгийн 24, “Ярилцах цаг” нэвтрүүлгийн 22, “10 секунд”-ын мэдээ 118, “Фото мэдээ”-ний 106, “Долоо хоногийн онцлох 5 мэдээ”-ний 24, “Аваргыг онцолъё” нэвтрүүлгийн 5, “Сэтгэл зүйчтэй ярилцъя” нэвтрүүлгийн 8, “Долоо хоногийн онцлох тойм” мэдээний 24, “Police podcast” хөтөлбөрийн 19 дугаар, нийт 350 төрлийн нэвтрүүлэг, ярилцлага, мэдээ, мэдээлэл бэлтгэн Цагдаагийн ерөнхий газрын вэб сайт, төвийн фэйсбүүк, твиттер хуудас, мэдээллийн сайтууд болон МҮОНТ болон өргөн нэвтрүүлгийн 12 телевизээр нэвтрүүлэн иргэд, олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулан ажилласан.

**2.9.Зохион байгуулсан спорт, урлагийн арга хэмжээний чиглэлээр:** Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн 2021 оны А/277 дугаар тушаалаар Монгол Улсад орчин цагийн цагдаагийн байгууллага үүсэж хөгжсөний 101, дотоодын цэргийн 100 жилийн ойн нэрэмжит цагдаа, дотоодын цэргийн байгууллагын дунд 15, ахмад ажилтнуудын дунд 2, байгууллагыг иргэд, олон нийтэд сурталчлах 1, нийт 18 төрлийн спортын уралдаан, тэмцээн зохион байгуулахаас энэ оны эхний хагас жилд “Дартс”, “Ширээний теннис”, “Хүчний 3 төрөлт”, “Софт волейбол”, “Дуатлон”, “Олс таталт” зэрэг 7 тэмцээнийг зохион явуулж, цагдаа, дотоодын цэргийн 62 анги, байгууллагын 785 алба хаагч, 152 ахмад ажилтныг хамруулсан.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын ахмад, залуучууд, өсвөр үеийн давхардсан тоогоор 187 тамирчин чөлөөт, жүдо, самбо, кураш, бүстэй бөх, хүндийн өргөлт, холимог тулаан, пауэрлифтинг, бокс, таеквондо, буудлага зэрэг спортын 11 төрлөөр улс, олон улсын хэмжээний 25 удаагийн тэмцээнд амжилттай оролцож, нийт ганцаарчилсан төрөлд 52 алт, 34 мөнгө, 44 хүрэл медаль хүртэж, багийн дүнгээр “Дэд байр” 2, “Гутгаар байр” 1 удаа тус тус эзэлсэн.

Монгол Улсын Ерөнхий сайдын санаачилсан “Илүүдэл жингүй-Эртэч Монгол” аянд нэгдэх арга хэмжээг Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир, спортын улсын хороотой хамтран “Спортын төв ордон”-д зохион байгуулж, биеийн тамирын дасгал хөдөлгөөнд Улаанбаатар цагдаагийн хүрээний 16 анги, байгууллагын 250 алба хаагчийг хамруулж, тус аяныг дэмжих 302 удаагийн арга хэмжээнд нэгдэн оролцож, цасны баяр 1, явган аялал 64, ажлын байрны дасгал хөдөлгөөн 539, тэмцээн уралдаан 165, яриа таниулга 313, цахим хичээл 92, соён гэгээрүүлэх 247 ажлыг төрийн болон төрийн бус 98 байгууллагатай хамтран зохион байгуулж, давхардсан тоогоор 45837 алба хаагч, ажилтныг хамруулж, 329 гарын авлага, зөвлөмж боловсруулж үйл ажиллагаандаа ашигласан.

Монгол Цэргийн өдөр, Зэвсэгт хүчний түүхт 101 жилийн ойд зориулсан төрийн цэргийн болон хууль сахиулах тусгайлсан чиг үүрэгтэй 10 байгууллагын удирдах бүрэлдэхүүний дунд зохион байгуулагдсан бильярд, гар бөмбөгийн “Нөхөрсөг-уулзалт” тэмцээнд 4 дүгээр байрт шалгарсан.

Монгол цэрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг дэмжих ажиллагаанд оролцож эхэлсний 20 жилийн ойн нэрэмжит Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын “Волейбол”, “Сагсан бөмбөг”-ийн тэмцээнд “Дэд” байр эзэлж,

“Энхийн төлөө-Эрүүл амьдрал” бүх нийтийн гүйлтийн тэмцээнд 18 алба хаагч оролцсоноос 1 мөнгө, 1 хүрэл медаль хүртсэн.

Монголын Мөсөн сурын багийн болон цуваа харвааны 2022 оны Улсын аварга шалгаруулах тэмцээнд цагдаа, дотоодын цэргийн байгууллагыг төлөөлөн 10 алба хаагч оролцсон. Тэмцээнд 36 баг оролцсоноос цагдаа, дотоодын цэргийн байгууллагын баг “Шигшээ найм”-д шалгарч, 2 алба хаагч спортын мастер, дэд мастерын болзол хангаж, 1 алба хаагчид мөсөн сурын “Улсын мэргэн” цол олгосон.

Ардын хувьсгалын 100, 101, Цагдаагийн байгууллагын 101 жилийн ойд зориулан Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Төрийн соёрхолт, Урлагийн гавьяат зүтгэлтэн С.Сүхбаатарын зохиол, найруулгаар тус чуулгын уран бүтээлчид “Эрхэм төрийн тамгат баатрууд” түүхэн дуулалт дуулийг дэглэн тавьж, уг бүтээлийг иргэд, олон нийтэд хүргэх зорилгоор МҮОНТ-ээр бичүүлж, Univision-д байршуулан олон нийтэд хүргэсэн.

Монгол Улсын Төрийн дууллыг Сүлд чуулгын уран бүтээлчид дуулснаар хийсэн бичлэг болон Сүлд чуулгаас зохион байгуулсан бүрэн хэмжээний тоглолтууд болох “Монгол минь амгалан байна”, “Жаргалтайн дэлгэр Монгол” зэрэг уран бүтээлүүдийг орон нутгийн телевизүүдийн холбоотой контент нийлүүлэх гэрээ байгуулан орон нутгийн 50 гаруй телевизээр гаргаж олон нийтийн хүртээл болгож байна.

Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд Токио Хотын Их Театрт болох Дэлхийн Цагдаагийн Хөгжмийн Холбооны 2 дахь удаагийн тусгай дугаарын концертод (2nd special edition World Police Band Concert 2022) чуулгын үлээвэр найрал хөгжмийн хэсгийг албан ёсоор оролцуулах ажлыг амжилттай зохион байгуулсан.

Монгол Улсын Засгийн газар, Соёлын яамнаас Нийгмийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, үндэсний өв уламжлал, ёс заншил, соёлын онцлогийг агуулсан, дэвшилтэт технологи, инновацид суурилсан, импортыг орлох, экспортод чиглэсэн өрсөлдөх чадвартай бүтээлийг шалгаруулах оны шилдэг уран бүтээл болон уран бүтээлчийг шалгаруулах 13 дахь удаагийн “Мөнгөн мод-2021” шалгаруулалтад шилдэг уран бүтээл шалгаруулах 6 төрөлд, шилдэг уран бүтээлчийн шалгаруулалтад 4 төрөлд өрсөлдөж шилдэг бүжиг дэглээч төрөлд тус чуулгын бүжгийн багш, дэглээч, цагдаагийн ахлах дэслэгч Ё.Дамчаабадгар, шилдэг хөгжмийн зохиолч төрөлд хөгжимчин, цагдаагийн дэд ахлагч В.Баттулга, шилдэг виртуал үзмэр төрөлд Цагдаагийн виртуал музей шилдэг 3-д шалгаран үлдэж амжилттай оролцсон.

### **Гурав. Санхүү бүртгэл, хангамж үйлчилгээний ажлын талаар**

Монгол Улсын Их Хурлаас 2022 онд цагдаа, дотоодын цэргийн байгууллагын төсвийн урсгал зардлыг 277.8 тэрбум, хөрөнгө оруулалтын зардлыг 11.1 тэрбум, нийт 289.0 тэрбум төгрөгөөр, өмнөх оноос 10.9 хувиар нэмэгдүүлэн батлуулсан. 2022 онд 568 орон тоо нэмэгдүүлж, 24.3 тэрбум төгрөгийн урсгал зардлыг урд оноос нэмэгдүүлсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 99 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар “Цагдаагийн алба хаагчдад мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох журам”-ын хэрэгжилтийг хангах зорилгоор Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн “Мэргэжлийн зэргийн нэмэгдэл олгох тухай” А/184 дүгээр тушаалаар 77 анги, байгууллагын 10.190 алба хаагчаас авсан шалгалтын үр дүнгээр шалгалтад тэнцсэн 1248 алба хаагчид энэ оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс зэргийн нэмэгдлийг олгож эхэлсэн.

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын шөнийн ээлжинд хонож ажилласан “диспетчер, сантехникч” нарт 2022 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хоногийн 10,000 /арван мянган/ төгрөгийн хоолны мөнгө олгохоор шийдвэрлэсэн.

Тендер хүлээн авч байгаа 6 төсөл, арга хэмжээ, үнэлгээ хийгдэж буй 2, үр дүн гарсан 30 буюу давхардсан тоогоор нийт 38 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн урилга, үр дүнг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn), [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn)-нд болон өдөр тутмын сонин хэвлэлд холбогдох хууль, журмын дагуу байршуулж, олон нийтэд ил тод мэдээлж байна.

Цагдаа, дотоодын цэргийн 54 анги, байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хүлээн авч, Сангийн яамны “Э-тайлан”-ийн системд нэгтгэн Үндэсний аудитын газарт хуулийн хугацаанд хүргүүлсэн.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын автопаркийг шинэчлэх ажлын хүрээнд “Киа моторс монгол” ХХК-тай тусгай дуут гэрлэн дохио, техник хэрэгслээр тоногдсон 5 төрлийн 350 автомашиныг 4 жилийн хугацаатай түрээсийн журмаар худалдан авах гэрээг байгуулж, 336 автомашиныг хүлээн авч, Улаанбаатар цагдаагийн хүрээ болон орон нутгийн цагдаагийн газар, хэлтэст хуваарилан олгоод байна.

“Сүүж-Уул” амралт, сэргээн засах сувилалд Эрүүл мэндийн даатгалын хөнгөлөлттэй үнээр буюу үнэ төлбөргүй цагдаа, дотоодын цэргийн 49 анги, байгууллагын 437 алба хаагч, ажилтныг хуваарь гарган хүлээн авч, цагдаагийн байгууллагын 71 ахмад ажилтныг хөнгөлөлттэй үнээр хамруулсан.

Цагдаа, дотоодын цэргийн алба хаагч, ахмад ажилтны эрүүл мэндийг дэмжих, сэргээн засах, эмчилгээ үйлчилгээ үзүүлэх зорилгоор Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас зарласан сонгон шалгаруулалтын шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн “Сүүж-Уул” амралт, сэргээн засах сувиллын нэршлийг “Сүүж-Уул” амралт, сувилал болгон өөрчилж, бүтэц орон тоог шинэчлэн 3 их эмч, 2 сувилагчийн орон тоог нэмэгдүүлэн магадлан итгэмжлэлд оруулж, Эрүүл мэндийн сайдын 2022 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн А/286 дугаар тушаалаар магадлан илтгэмжлэл олгосон.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 155, 2019 оны 431, 2021 оны 17 дугаар тогтоолоор баталсан цагдаагийн алба хаагчийн 6 бүлгийн 68 нэр төрлийн дүрэмт хувцас, ялгах тэмдгийг материалд тавигдах 11 багц стандартын төслийг эцэслэн хянаж, холбогдох техник ажиллагааг хийж, Стандартчилал, хэмжил зүйн газраар хянуулан дугаар авч, “Байгууллагын стандарт” болгон тус тус батлуулсан байна.

## ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР